

Партизаны Сангийн аж ахуй

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1976 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 429 тоот тогтоолд : Аюушийн аманд байгаа барилга байгууламж болон 800 үнээний сүүний механикжсан фермийг түшиглэн Партизаны САА-г 1977 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн байгуулсугай. /Гачууртын САА-аас СНЗ-ын 42 тоот тогтоолоор УБХ-ын АДХГЗ-ны захирамжаар томилогдсон комисс салгаж зохион байгуулах 1977 оны 01 дүгээр сарын 14-нөөс 22-ний хооронд явууллаа.

1977-3-16-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 64-р зарлигаар Улаанбаатар хотын “Партизан” сангийн аж ахуйг харьяалсан Партизаны хороо, төв нь “Жаргалант” шинээр байгуулжээ.

1977 оны 12-25-ны байдлаар Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяа газар, байгууллага нь:

1. Нэгдлийн захын контор
2. Улаанбаатар хотын барилга- архитектурын газар
3. Хот цэцэрлэгжүүлэх трест
4. Усны аж ахуй, ашиглалтыг удирдах газар
5. Гэрэлтүүлэг, чимэглэлийн үйлдвэр
6. Кино контор
7. Гэрлэх ёслолын ордон
8. Улаанбаатар хотын барилга засварын нэгдсэн трест
9. Хотын мал эмнэлгийн газар
10. Гачууртын сангийн аж ахуй
11. Партизаны сангийн аж ахуй
12. Шувуу фабрик
13. Гахай бордох завод
14. Ногооны комбинат

Хүнсний барааны өөртөө үйлчлэх их дэлгүүр /универсам/тус тус байжээ.